

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1	ЗГ, УОК-оос тогтоосон хөл хорионы улмаас БҮТП-ийн тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг 3 дугаар сард шийдвэрлүүлэхээр түр хойшлуулсан.	-
2.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	<ul style="list-style-type: none"> - БХБЯ-ны захиалгаар Мон-Энержи Консалт ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийг баталгаажуулах явцад хяналт тавьж байна. - НШУУИГ-ын дарга, мэргэжилтнүүдтэй 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр цахим зөвлөгөөн хийж, Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг хэлэлцэж, НЗД-ын УЗХ-д оруулах саналуудаа танилцуулсан. - 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Паркийн ерөнхий дэд станцаас Хүнд үйлдвэрийн бүсэд хүрэх эрчим хүчийг хангах 35/10 кВ-ын дэд станцын зураг төслийг гүйцэтгүүлэн Багануур дүүргийн ЗӨБС ЦДҮС ТӨХК, ГЗБА, ЗӨБЦТС ТӨХК зэрэг мэргэжлийн инженер техникийн ажилчид, дэд бүтцийн байгууллагуудын холбогдох дарга, мэргэжилтнүүд болон БҮТП ОНӨТҮГ-ын дарга хянан баталгаажуулан гарын үсэг зурж ЦДҮС ТӨХК-д хянуулахаар шилжүүлсэн. - 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр дээрх зураг төслийг Нийслэлийн онцгой байдлын газарт хянуулахаар хүргүүлсэн. - Паркийн цахилгаан хангамжийн 110 кВ-ын 7.3 км өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийг ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөж, нэмэлт өөрчлөлтийг оруулан баталгаажуулахаар бэлтгэж байна. 	100%
3.	Засгийн газрын 2020 оны 216, 217 дугаар тогтоол	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын 2021 оны стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжийн төлөвлөгөөг боловсруулж удирдлагаар батлуулах - Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан. - НШУУИГ-ын стратеги төлөвлөгөө батлагдсаны дараа байгууллагын стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтийг оруулан батлуулна. - Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалын 4 дүгээр 	70%

		<p>хавсралтын дагуу боловсруулж нэмэлт өөрчлөлт оруулан нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар батлав. 	
4.	Хамтын ажиллагаа	Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан төлөвлөгөөнд цар тахалтай холбоотойгоор өөрчлөлт оруулсан.	100%
5.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - 2021 оны 01 дүгээр сарын 30-наас 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар хариутай 9, хариугүй 9 нийт 18 албан бичиг ирсэн ба албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 95,56%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1.11 - “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 14 хариугүй бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. 	100%
6.	ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд баяжилтийг тогтмол хийж, ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байна. - Байгууллагын цахим хуудсанд 2021 оны 01 дүгээр сарын 30-наас 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар байгууллагын дотоод үйл ажиллагааны 4, цар тахалтай холбоотой 6 мэдээллийг байршуулсан. 	100%
7.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> - 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Нийслэлийн Дотоод аудитын газрын хүсэлтээр манай байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийхэд шаардагдах баримт бичиг, материалуудыг тус газрын мэрэгжилтэн Дотоод аудитор Ж.Сайханбаярт ERP хаягаар нь хүргүүлсэн. - НУӨАГ-т байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын судалгааг гаргаж хүргүүлсэн. - Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 22 дугаартай албан бичгээр НТАГ-т хүргүүлсэн. - www.shilendans.mn сайтад Байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна. 	100%
8.	Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаал	<ul style="list-style-type: none"> - 2020 оны А-42, Б-33 тушаалыг jpg, pdf форматаар ялган скандардаж archive.mn программ оруулж эхэлсэн. - Ажилтнуудаас 2020 онд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг батлагдсан хуваарийн дагуу хүлээн авч байна. 	40%
НЭМЭЛТ АЖИЛ			
9.	НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 7 хоног тутам НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хүргүүлэн ажиллаж байна.		100%

10.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна.	100%
11.	Нийслэл, дүүргийн удирдах ажилтнуудын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит (цахим) шуурхай зөвлөгөөн дээр нийслэл, дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээг 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж тайланг дүүргийн ЗАА-нд хүргүүлсэн.	100%
12.	НОК-ын 2021 оны 01 дугаар сарын 05-ны өдрийн 06 дугаар цахим хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу "Дэм дэмэндээ" аяныг үргэлжлүүлэн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж, паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-тай хамтран зорилтот бүлгийн 10 айл өрхөд хүнс тэжээлийн туслалцаа үзүүлсэн.	100%
13.	Багануур дүүргийн ЗДТГ-аас 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын танилцуулга сэдэвт сургалтанд Паркийн удирдлага, Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн нар хамрагдсан.	100%
14.	Багануур дүүргийн ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 03/40 дугаартай албан бичгийн дагуу Коронавирус /Ковид 19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд нийслэлийн Онцгой комиссоос зохион байгуулж буй "Нэг хаалга-Нэг шинжилгээ" ажиллагаанд оролцох албан хаагчдын мэдээллийг гаргаж, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаартай албан бичгээр дүүргийн ТЗУХ-т хүргүүлсэн.	100%
15.	НЗД-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу "Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээнд хамрагдсан албан хаагчид, тэдний гэр бүлийн мэдээллийг UB ERP системийн Хүний нөөцийн удирдлага дэд системд оруулан бүртгэсэн. 2 албан хаагчийн гэр бүлийн гишүүний регистрийн дугаар олдоогүй алдаа гарсан учир нийслэлийн Мэдээлэл технологийн газрын Н.Эрдэнэболд мэргэжилтэнд мэдэгдэн шалгуулж байна. Алдааг засагдсан даруйд мэдээллийг ERP системд бүртгэнэ.	100%
16.	НШУҮИГ-ын 02 дугаар сарын 17-ны өдрийн 02/39 дугаартай албан бичгийн дагуу Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 2020-2021 онд нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулахаар тусгагдсантай холбогдуулан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналыг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100%
17.	НШУҮИГ-ын 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/42 дугаартай албан бичгийн дагуу "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний төсөлд тусгах саналыг боловсруулан Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 21 дугаартай албан бичгээр болон buyantogtokh.sidia@gmail.com цахим хаягаар тус тус хүргүүлэв.	100%
18.	2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай хурлын үеэр НЗД-ын өгсөн үүрэг даалгаврын дагуу дараах баримт бичгийг холбогдох газарт нь хүргүүлж ажилласан. - ЗГ-ын 21 дүгээр тогтоол, НЗД-ын А/85, А/86, А/87 захирамжуудын хэрэгжилтийг Даргын зөвлөлийн хурлаар 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдөр хэлэлцэн дүгнэж, тайланг мөн өдрийн 24 дугаартай албан бичгээр НОК-т, - Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах саналыг ажилтан нараас авч нэгтгэн Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаартай албан бичгээр НЗДТГ-т тус тус хүргүүлсэн.	

19.	Архивын Ерөнхий газраас 2021 оны 02 дугаар сарын 22, 23-ны өдөр зохион байгуулсан "ХХНЖ боловсруулах арга зүй" сэдэвт цахим сургалтад Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн оролцсон.	100%
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
20.	Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	100%
21.	Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна.	100%
22.	Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна.	100%
23.	УОК-ын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 730 дугаартай албан бичгээр өгсөн мэдээлэл, ажлын чиглэлийг албан хаагчдад танилцуулан 9 дэхь заалтын дагуу байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчил дутагдалгүй ажилласан.	100%
24.	Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол хүн амын дунд хурдацтай тархахаас сэргийлэх зорилгоор Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан "Нэг хаалга-нэг шинжилгээ" үйл ажиллагаанд байгууллагын ажилтан нар дайчлагдан ажилласан тухай илтгэх хуудсыг 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	100%
25.	Нийслэл, дүүргийн ЗДТГ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу байгууллагын 12 албан хаагчдаас 0-3 насны хүүхэдтэй 2 албан хаагчийг чөлөөлж, нийт 10 ажилтан Багануур дүүргийн 5 хороонд зохион байгуулсан "Нэг хаалга-Нэг шинжилгээ" үйл ажиллагаанд явцын хяналт тавьж, дүн мэдээг нэгтгэн нийслэлийн шуурхай штабт мэдээлж, илтгэх хуудас болон уг арга хэмжээнд оролцсон албан хаагчдын мэдээллийг НЗДТГ-т хүргүүлсэн.	100%

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН.
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

F. Anabala

Э.ЭНХЗАЯА